



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баянхонгор аймгийн Галуут сумын Цэцэрлэгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: БНА-2026/023/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Баянхонгор хот
2026 оны 02 дугаар сар 08

Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор Б.Мөнхбат
Утас: 70442584 Цахим хаяг: munkhbat.b@audit.gov.mn
Аудитын менежер М.Алтантуяа
Утас: 70442424 Цахим хаяг: altantuyam@audit.gov.mn
Ахлах аудитор Б.Нарангэрэл
Утас :99009293, Цахим хаяг :Narangerelb@audit.gov.mn
Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: "СМД аудит" ХХК
Захирал :Д.Гэндэнпэлжээ
Утас: 99110699, Цахим хаяг: CMD.audit@yahoo.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	4
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	6
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	6
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	7
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	8
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	10
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	10
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	12
4.АУДИТЫН ТАЙЛАН.....	16
4.1 Ерөнхий зүйл.....	16
4.2 Материаллаг байдал	16
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	16
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	16
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	17
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	17
4.5.1 Завсрын аудитын талаар	17
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	17
5.АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ.....	18
5.1.Зөвлөмж.....	18
6.АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	19

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар





ГАЛУУТ СУМЫН ЦЭЦЭРЛЭГИЙН
ЭРХЛЭГЧ Б.САЙНЗАЯА ТАНАА

**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

310 дугаар байр, Лувсанданзанжанцангийн
өргөн чөлөө 3 дугаар гудамж, Номгон 1 дүгээр баг,
Баянхонгор сум, Баянхонгор аймаг, 64101
Утас: (976) 70442584

Цахим шуудан: procurement_bayankhongor@audit.gov.mn

2026.02.24 № 9/45

танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Галуут сумын Цэцэрлэгийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг баримталсан байна. Цаашид тус байгууллагын чиг үүрэг өөрчлөгдөх, татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар онцолсон нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

Төсвийн тодотгол хийхдээ орон нутгийн төсвийн санхүүжилтийг бууруулснаас 2,774,8 мянган төгрөгийн өглөг үүссэн байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна.

6426050138

/2026 он/1. бичиг хэрэг/тоот/2. а4-
албан тоот.docx

Тайлант онд тус байгууллага нь монгол бичгийн программын төлбөрт 16.5 мянган төгрөг, төсвийн гүйцэтгэлийн мэдээний программын төлбөрт 160.0 мянган төгрөг, суралцахуйн удирдлагын системийн Арта программын үйлчилгээний төлбөрт 585.0 мянган төгрөгийг тус тус төлж байгаа асуудлыг дээд шатны захирагч анхаарах шаардлагатай байна

Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Бусад асуудлын хэсэг

Аудитын дээд байгууллагын олон улсын стандартын дагуу аудитын мөрөөр хяналт тавих арга хэмжээ буюу өмнөх аудитаар өгсөн аудитын шийдвэрт дурдсан асуудлыг шалгагдагч байгууллага хэрхэн хэрэгжүүлж, шийдвэрлэснийг аудитор хянаж, үнэлэх үүрэг хүлээдэг.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага


Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР

Б.МӨНХБАТ



2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

2025 оны 12 дугаар сарын 31-нээр дуусвар болсон

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	250,730,047.65	142,085,068.00
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	165,108,236.06	45,785,106.41
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	165,108,236.06	45,785,106.41
3121	Төгрөг	165,108,236.06	45,785,106.41
31211	Төрийн сангийн харилцах	165,108,236.06	45,785,106.41
33	АВЛАГА	325,650.00	00.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	325,650.00	00.00
35	БАРАА МАТЕРИАЛ	85,296,161.59	96,299,961.59
351	Түүхий эд материал	270,000.00	160,000.00
35130	Эм боох материал	270,000.00	160,000.00
354	Хангамжийн материал	85,026,161.59	96,139,961.59
35410	Бичиг хэргийн материал	169,500.00	169,500.00
35420	Аж ахуйн материал	82,966,661.59	93,982,961.59
35450	Барилгын засварын материал	1,630,000.00	1,630,000.00
35460	Хүнсний материал	00.00	97,500.00
35470	Бусад хангамжийн материал	260,000.00	260,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	794,572,343.06	782,056,699.93
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	794,572,343.06	782,056,699.93
392	Биет хөрөнгө	784,548,343.06	772,120,699.89
39201	Барилга, байгууламж, орон сууц	831,159,443.00	837,294,443.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-71,118,517.89	-83,970,170.57
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	58,535,990.00	41,380,810.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-43,843,804.98	-33,504,965.35
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	50,452,780.07	48,603,656.45
39208	Хуримтлагдсан элэгдэл	-44,544,947.14	-41,284,573.64
39217	Ном	3,907,400.00	3,601,500.00
393	Биет бус хөрөнгө	10,024,000.00	9,936,000.04
39301	Програм хангамж	522,500.00	522,500.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-82,500.00	-170,499.96
39303	Бусад биет бус хөрөнгө	9,584,000.00	9,584,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,045,302,390.71	924,141,767.93
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	00.00	2,774,831.50
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	00.00	2,774,831.50
413	Өглөг	00.00	2,774,831.50
4136	Бусад өглөг	00.00	2,774,831.50
41361	Байгууллагад төлөх өглөг	00.00	2,774,831.50
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,045,302,390.71	921,366,936.43
51	Засгийн газрын хувь оролцоо	1,045,302,390.71	921,366,936.43
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	120,750,300.93	120,750,300.93
51101	Өмч: - төрийн	120,750,300.93	120,750,300.93
512	Хуримтлагдсан үр дүн	248,356,563.87	124,421,109.59



Галуут сумын Цэцэрлэгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

51210	Өмнөх үеийн үр дүн	248,356,563.87	248,356,563.87
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-123,935,454.28
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	676,195,525.91	676,195,525.91
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,045,302,390.71	924,141,767.93

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Төгрөгөөр/

2025 оны 12 дугаар сарын 31-нээр дуусвар болсон

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	720,481,716.59	743,999,680.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	32,079,420.59	7,098,380.00
120	Нийтлэг татварын бус орлого	32,079,420.59	7,098,380.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	142,140.00	98,380.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	142,140.00	00.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	98,380.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	688,402,296.00	736,901,300.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	635,641,100.00	669,828,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	635,641,100.00	669,828,500.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	52,715,300.00	67,072,800.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	52,715,300.00	67,072,800.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	45,896.00	00.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	45,896.00	00.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	665,459,758.02	867,465,900.91
21	УРСГАЛ ЗАРДАЛ	665,459,758.02	867,465,900.91
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	665,412,149.02	861,770,145.41
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	458,549,477.00	620,084,501.00
210101	Үндсэн цалин	314,710,221.00	593,670,961.00
210102	Нэмэгдэл	135,670,656.00	00.00
210104	Урамшуулал	8,168,600.00	26,413,540.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	55,932,715.00	77,242,058.65
210201	Тэтгэврийн даатгал	35,557,823.00	51,728,658.65
210202	Тэтгэмжийн даатгал	5,094,000.00	6,378,400.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,546,192.00	3,189,200.00
210204	Ажилгүйдлийн даатгал	2,546,900.00	3,189,200.00
210205	Эрүүл мэндийн даатгал	10,187,800.00	12,756,600.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	50,715,287.00	63,441,876.00
210301	Гэрэл, цахилгаан	3,500,000.00	6,594,323.50
210302	Түлш, халаалт	46,015,287.00	56,247,552.50
210303	Цэвэр, бохир ус	1,200,000.00	600,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	17,734,548.10	11,494,590.00
210401	Бичиг хэрэг	4,489,950.00	8,233,190.00
210402	Тээвэр, шатахуун	1,625,900.00	2,674,000.00

Галуут сумын Цэцэрлэгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	343,200.00	00.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	90,000.00	00.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	00.00	587,400.00
210408	Бараа материал акталсны зардал	11,185,498.10	00.00
2105	Нормативт зардал	49,048,120.00	51,643,160.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	00.00	110,000.00
210502	Хоол, хүнс	49,048,120.00	51,533,160.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,998,300.00	5,993,900.00
210604	Урсгал засвар	1,998,300.00	5,993,900.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	465,000.00	2,351,500.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	465,000.00	2,351,500.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	30,968,701.92	29,518,559.76
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	8,859,470.00	7,967,150.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	22,109,231.92	21,551,409.76
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	47,609.00	5,695,755.50
2132	Бусад урсгал шилжүүлэг	45,896.00	5,283,900.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	45,896.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	00.00	5,283,900.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	1,713.00	411,855.50
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,713.00	411,855.50
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	55,021,958.57	-123,466,220.91
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	00.00	469,233.37
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	00.00	469,233.37
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	00.00	-469,233.37
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	55,021,958.57	-123,935,454.28

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

2025 оны 12 дугаар сарын 31-нээр дуусвар болсон

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	688,544,436.00	736,999,680.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	142,140.00	98,380.00
120	Нийтлэг татварын бус орлого	142,140.00	98,380.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	142,140.00	98,380.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	142,140.00	00.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	98,380.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	688,402,296.00	736,901,300.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	635,641,100.00	669,828,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	635,641,100.00	669,828,500.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	52,715,300.00	67,072,800.00

Галуут сумын Цэцэрлэгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	52,715,300.00	67,072,800.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	45,896.00	00.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	45,896.00	00.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	646,700,608.00	853,817,809.65
21	УРСГАЛ ЗАРДАЛ	646,700,608.00	853,817,809.65
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	646,652,999.00	848,122,054.15
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	458,527,207.00	619,758,847.04
210101	Үндсэн цалин	313,108,640.00	387,384,279.00
210102	Нэмэгдэл	135,670,656.00	192,778,389.04
210103	Унаа хоолны хөнгөлөлт	00.00	13,087,173.00
210104	Урамшуулал	9,747,911.00	26,509,006.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	56,280,635.00	77,242,062.61
210201	Тэтгэврийн даатгал	35,905,035.00	51,728,662.61
210202	Тэтгэмжийн даатгал	5,094,000.00	6,378,400.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,546,900.00	3,189,200.00
210204	Ажилгүйдлийн даатгал	2,546,900.00	3,189,200.00
210205	Эрүүл мэндийн даатгал	10,187,800.00	12,756,600.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	50,715,287.00	60,667,044.50
210301	Гэрэл, цахилгаан	3,500,000.00	6,594,323.50
210302	Түлш, халаалт	46,015,287.00	53,472,721.00
210303	Цэвэр, бохир ус	1,200,000.00	600,000.00
2105	Нормативт зардал	49,048,120.00	51,630,660.00
210502	Хоол, хүнс	49,048,120.00	51,630,660.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,998,300.00	5,993,900.00
210604	Урсгал засвар	1,998,300.00	5,993,900.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,055,000.00	3,195,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,055,000.00	3,195,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	28,028,450.00	29,634,540.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	21,971,650.00	23,542,500.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	6,056,800.00	6,092,040.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	47,609.00	5,695,755.50
2132	Бусад урсгал шилжүүлэг	45,896.00	5,283,900.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	45,896.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	00.00	5,283,900.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	1,713.00	411,855.50
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,713.00	411,855.50
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	41,843,828.00	116,818,129.65
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	00.00	2,505,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	00.00	2,505,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	00.00	2,505,000.00



Галуут сумын Цэцэрлэгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	00.00	2,505,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	00.00	-2,505,000.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	41,843,828.00	119,323,129.65
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	123,264,408.06	165,108,236.06
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	165,108,236.06	45,785,106.41

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-нээр дуусвар болсон					/төгрөгөөр/
№	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	120,750,300.93	676,195,525.91	248,356,563.87	1,045,302,390.71
2	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	120,750,300.93	676,195,525.91	248,356,563.87	1,045,302,390.71
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	120,750,300.93	676,195,525.91	248,356,563.87	1,045,302,390.71
4	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-123,935,454.28	-123,935,454.28
5	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	120,750,300.93	676,195,525.91	124,421,109.59	921,366,936.43

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

2025 оны 12 дугаар сарын 31-нээр дуусвар болсон

Эдийн засгийн ангилал		төлөвлөгөө	Гүйцэтгэл	зөрүү	хувь
1	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	891,632,000.00	736,999,680.00	154,632,320.00	82.66
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	679,277,700.00	669,828,500.00	9,449,200.00	98.61
131001	Улсын төсвөөс санхүүжих	679,277,700.00	669,828,500.00	9,449,200.00	98.61
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	67,072,800.00	66,661,044.50	411,755.50	99.38
132001	Орон нутгийн төсвөөс	67,072,800.00	66,661,044.50	411,755.50	99.38
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН	145,281,500.00	98,380.00	145,183,120.00	0.07



Галуут сумын Цэцэрлэгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

	ҮЙЛ АЖИЛЛАГААНААС				
120004	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	145,281,500.00	00.00	145,281,500.00	0.00
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	891,632,000.00	855,910,954.15	35,721,045.85	95.99
21	УРСГАЛ ЗАРДАЛ	891,632,000.00	855,910,954.15	35,721,045.85	95.99
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	886,348,100.00	850,627,054.15	35,721,045.85	95.97
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	640,486,300.00	619,758,847.04	20,727,452.96	96.76
210101	Үндсэн цалин	411,315,300.00	387,384,279.00	23,931,021.00	94.18
210102	Нэмэгдэл	211,626,700.00	192,778,389.04	18,848,310.96	91.09
210104	Урамшуулал	17,544,300.00	26,509,006.00	8,964,706.00	151.1
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	79,573,300.00	77,242,062.61	2,331,237.39	97.07
210201	Тэтгэврийн даатгал	53,956,900.00	51,728,662.61	2,228,237.39	95.87
210202	Тэтгэмжийн даатгал	6,404,100.00	6,378,400.00	25,700.00	99.60
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,202,100.00	3,189,200.00	12,900.00	99.60
210204	Ажилгүйдлийн даатгал	3,202,100.00	3,189,200.00	12,900.00	99.60
210205	Эрүүл мэндийн даатгал	12,808,100.00	12,756,600.00	51,500.00	99.60
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	61,072,800.00	60,667,044.50	405,755.50	99.34
210301	Гэрэл, цахилгаан	7,000,000.00	6,594,323.50	405,676.50	94.20
210302	Түлш, халаалт	53,472,800.00	53,472,721.00	79.00	100.00
2105	Нормативт зардал	63,804,500.00	51,630,660.00	12,173,840.00	80.92
210502	Хоол, хүнс	63,804,500.00	51,630,660.00	12,173,840.00	80.92
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,000,000.00	5,993,900.00	6,100.00	99.90
210604	Урсгал засвар	6,000,000.00	5,993,900.00	6,100.00	99.90
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,199,300.00	3,195,000.00	4,300.00	99.87
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,199,300.00	3,195,000.00	4,300.00	99.87
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	32,211,900.00	32,139,540.00	72,360.00	99.78
210901	Бараа үйлчилгээний бусад	26,119,800.00	26,047,500.00	72,300.00	99.72

Галуут сумын Цэцэрлэгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

	зардал				
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	6,092,100.00	6,092,040.00	60.00	100.0
63	СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)	130	110	20	84.62
631	СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГА	130	110	20	84.62
631001	Төрийн өмчит СӨБ байгууллага	130	110	20	84.62

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Галуут сумын Цэцэрлэг нь Боловсролын ерөнхий хууль, Сургуулийн өмнөх боловсролын тухай хуульд тодорхойлсон сургуулийн өмнөх боловсролыг олгох, хүүхдийг аюулгүй ээлтэй орчинд сурах таатай орчныг бүрдүүлэн эх оронч, хүнлэг, бүтээлч хүүхдийг бэлтгэх, сургуулийн өмнөх боловсролын талаар баримтлах сургалтын бодлого, журам, дүрэм, хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд үйл ажиллагааны зорилго зорилтоо чиглүүлэн ажиллаж байна.

Галуут сумын Цэцэрлэг нь Боловсрол, шинжлэх ухааны яамнаас жил бүр дэвшүүлэн тавьсан зорилго зорилтыг хангах үүднээс байгууллагын үйл ажиллагааг хэвийн явуулах чиг үүргийн дагуу Захирлын 2025 оны 01 дүгээр сарын 02-ны өдрийн А/01 дугаар тушаалаар 27 орон тоотой ажиллахаар баталсан ба гүйцэтгэлээр 24 орон тоотой, 110 суралцагчтай үйл ажиллагаа явуулсан байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллага нь Төсвийн тухай, Төрийн албаны тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Хөдөлмөрийн тухай, Боловсролын ерөнхий хууль, Мэдээллийн ил тод байдлын тухай, Шилэн дансны тухай, Төрийн хэмнэлтийн тухай, Нийгмийн даатгалын тухай, Архивын тухай, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай болон Татварын багц хуулиудыг мөрдөж үйл ажиллагаа явуулж байна. Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авсан ба дотоод аудит гүйцэтгээгүй тул аудитад ашиглах баримт материал байхгүй, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

Тайлант онд Боловсролын ерөнхий газар болон аймгийн Боловсролын газраас хяналт, шинжилгээ, дотоод аудитын шалгалт хийгдээгүй байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Галуут сумын Цэцэрлэгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Галуут сумын Цэцэрлэгийн 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Байгууллагын үйл ажиллагаанд мөрдөж буй Баянхонгор аймгийн СТСХ-ээс бэлтгэн гаргасан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын жишиг баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Галуут сумын Цэцэрлэгийн 2025 оны санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-1 ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 121,160.6 мянган төгрөгөөр буюу 29.7 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	165,108.2	45,785.1	-119,323.1
Авлага	325.6	0	-325.6
Бараа материал	85,296.1	96,299.9	11,003.8
Үндсэн хөрөнгө	954,162.1	940,986.9	-13,175.2
Хуримтлагдсан элэгдэл	-159,589.8	-158,930.2	-659.6
Нийт хөрөнгө	1,045,302.3	924,141.7	(121,160.6)
Өр төлбөр		2,774.8	2,774.8
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	1,045,302.3	921,366.9	(123,935.4)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,045,302.3	924,141.7	(121,160.6)

Эх сурвалж: Галуут сумын Цэцэрлэгийн 2025 оны санхүүгийн тайлан

Дээрх хүснэгтээс харахад Галуут сумын Цэцэрлэгийн 2024 оны үзүүлэлтээс нөлөө бүхий өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө, бараа материал, үндсэн хөрөнгө, өглөгийн данс байна.

Тайлант оны эхэнд 165,108.2 мянган төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй байсан бол оны эцэст 45,785.1 мянган төгрөгийн үлдэгдэлтэй гарч өмнөх оноос 119,323.1 мянган төгрөгөөр буурсан байна.

Тайлант онд төсвийн хөрөнгөөр 83,971.6 мянган төгрөгийн бараа материал худалдан авч 72,967.8 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулж, 96,299.9 мянган төгрөгийн үлдэгдэлтэй гарсан нь өмнөх оноос 11,003.8 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна. Үүнээс аж ахуйн материал 11,016.3 мянган төгрөгөөр өссөн нь нөлөөлжээ.

Үндсэн хөрөнгө тайлант оны эхэнд 954,162.1 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байсан бол оны эцэст 940,986.9 мянган төгрөг буюу 13,175.2 мянган төгрөгөөр буурсан үзүүлэлттэй байна. Энэ нь тайлант онд сумын ОНХС-гийн эх үүсвэрээр 7,000.0 мянган төгрөгийн барилгын гадна шугам сүлжээний их засварын ажил хийгдсэн, төсвийн



хөрөнгөөр 2,205.0 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авсан буюу нийтдээ үндсэн хөрөнгө 9,505.0 мянган төгрөгөөр нэмэгдэж, аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн 2025 оны 7/38 тоот тогтоолоор ашиглалтын шаардлага хангахгүй болсон 22,680.2 мянган төгрөгийн хөрөнгийг акалж данснаас хассан нь нөлөөлсөн байна.

Тайлант оны эцэст 2,774.8 мянган төгрөгийн өглөгтэй гарсан нь орон нугийн тогтмол зардлын санхүүжилт бүрэн олгогдоогүйтэй холбоотой халаалтын зардлын өр үүсчээ.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 123,935.4 мянган төгрөгөөр буурч 921,366.9 мянган төгрөг болсон байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн, хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү данс өөрчлөлтгүй байна.

Тайлант онд тус байгууллага нь Санхүүгийн тооцоолох групп” ХХК-ны Acolous accounting system 4.0 санхүүгийн программ хангамж, нярвын программыг санхүүгийн үйл ажиллагаандаа ашиглаж, лицэнзийн төлбөрт 473.0 мянган төгрөгийг төлсөн байна. Мөн монгол бичгийн программын төлбөрт 16.5 мянган төгрөг, төсвийн гүйцэтгэлийн мэдээний программын төлбөрт 160.0 мянган төгрөг, суралцахуйн удирдлагын системийн Арта программын төлбөрт 585.0 мянган төгрөгийг тус тус төлсөн байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Төсвийн шууд захирагчийн 2025 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрт гүйцэтгэлийн санхүүжилтээр 657,013.5 мянган төгрөгийг улсын төсвөөс, тогтмол зардлын санхүүжилтэнд 72,694.0 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс авахаар тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчид хүргүүлсэн төсвийн төслөөс улсын төсвийн санхүүжилтийн эх үүсвэрийг 22,264.2 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн 679,277.7 мянган төгрөгөөр, орон нутгийн төсвийн санхүүжилтийн эх үүсвэрийг 5,615.8 мянган төгрөгөөр бууруулан 67,078.2 мянган төгрөгөөр тус тус баталжээ. Төсвийн төсөл өмнөх оны батлагдсан төсвөөс өндөр байгаа нь төрийн албан хаагчдын цалин хөлс, урсгал зардал нэмэгдсэнтэй холбоотой байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсөв захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 11 арга хэмжээг санхүүжүүлэх зардлын эх үүсвэрийг улсын төсвөөс 679,277.7 мянган төгрөг, төсөвт байгууллагын туслах үйл ажиллагааны орлого буюу урьд оны үлдэгдлээс 145,281.5 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 67,078.2 мянган төгрөг, нийт 891,630.0 мянган төгрөгийг зарцуулахаар төсвийг баталсан байна. Гүйцэтгэлээр улсын төсвөөс 669,828.5 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 67,078.2 мянган төгрөг, нийт 736,999.7 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урьд оны үлдэгдлээс 118,911.3 мянган төгрөг, нийт 855,910.9 мянган төгрөгийн зардалтайгаар үйл ажиллагаагаа явуулжээ. Үүнээс цалин, нийгмийн даатгалын зардлуудад 697,000.8 мянган, нормативт зардалд 51,630.6 мянган, бараа үйлчилгээний бусад зардалд 32,139.5 мянган, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөрт 3,195.0 мянган, нийт 736,999.7 мянган төгрөгийг зарцуулжээ. Орон нутгийн төсвөөс 67,072.8 мянган төгрөгийн санхүүжилт авч байр ашиглалтын зардалд 60,677.0 мянган, урсгал засварын зардалд 5,993.9 мянган, нийт 66,670.9 мянган төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 411.9 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлж, харилцах дансанд 45,785.1 мянган төгрөгийн үлдэгдэлтэй гарсан байна.

Галуут сумын Цэцэрлэгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Төсвийн улсын төсвийн нийт зардлын гүйцэтгэл 736,999.7 мянган төгрөг буюу 82.7 хувь, орон нутгийн төсвийн нийт зардлын гүйцэтгэл 66,670.9 мянган төгрөг буюу 99.4 хувьтай байгаа нь цалин хөлс, нийгмийн даатгалын шимтгэлийн зардал, нормативт зардлын хэмнэлттэй холбоотой байна. Нормативт зардлын хэмнэлт нь төсвийг төлөвлөхдөө 130 хүүхдийг хамруулахаар тооцсон боловч гүйцэтгэлээр дунджаар 110 хүүхэд хамрагдсан байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл
төгрөг/

/мянган

№	Код	Хөтөлбөр арга хэмжээ	ТӨЛӨВЛӨГӨӨ	ГҮЙЦЭТГЭЛ	Дүн	Хувь
1	80111	Нийтлэг үйлчилгээ	67,072.8	66,660.9	411,855.0	99.4
2	80233	Хүүхэд хамгаалал	1,322.7	1,320.0	2.7	99.8
3	81605	Эрүүл мэндийг дэмжих зардал	1,197.8	1,197.8	-	100
4	81807	Хоол, хүнс	59,520.5	49,338.6	10,181.9	82.9
5	81816	Хүүхдэд ээлтэй сургалтын орчин	2,172.4	2,165.0	7.4	99.7
6	81823	Боловсролын байгууллагын багш, ажилтны мэргэжил дээшлүүлэх	1,057.5	1,057.0	0.5	100
7	81832	Нүүдлийн бүлэгт хамруулах	40,047.8	33,062.0	6,985.7	82.6
8	81833	Явуулын багшийн үйлчилгээ	17,166.4	16,023.1	1,143.3	93.3
9	81834	Боловсролын стандарт, сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийг хэрэгжүүлэх	687,446.4	672,105.8	15,340.5	97.8
10	81835	Сургалтын хэвийн үйл ажиллагаа	14,592.7	12,980.6	1,612.1	89.0
11	81844	Гүнзгийрүүлсэн болон төрөлжсөн сургалт үйл ажиллагаа	35,000.0		35,000.0	
		ДҮН	891,632.0	855,911.0	35,721.0	96.0

Эх сурвалж: 2025 оны төсвийн гүйцэтгэлийн тайлан

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

Төрийн аудитын байгууллагаас 2025-2026 онд баримтлах ерөнхий чиглэлийн дагуу судалгааг авч үр дүнг нэгтгэв.

Цэцэрлэгийн эрхлэгчийн 2025 оны 01 сарын 02-ны А/01 тоот тушаалаар бүтэц орон тоог 26 орон тоотой, 640,409.5 мянган төгрөгийг зарцуулахаар төсөв баталсан бөгөөд бүтэц, орон тооны цомхотгол хийгээгүй, 3 багшийн орон тоо дутуу ажиллаж, цалингийн зардалд 619,758.8 мянган төгрөгийг зарцуулсан байна.

2. Тус байгууллага нь Засгийн газрын 2019 оны 6-р тогтоол, Боловсролын сайдын 2025.03.19 А/06 тушаал Боловсролын сайдын 2025 оны 02-р сарын 11-ний "Чиглэл хүргүүлэх тухай" 1/554 тоот албан бичгийг үндэслэн цэцэрлэгийн эрхлэгчийн 2025 оны 05 дугаар сарын 26-ны Б/11 дугаар тушаалаар өдрийн хоолны зардлыг 5.0 мянган төгрөгөөр тогтоон, тайлант хугацаанд 13,087.2 мянган төгрөгийг олгосон байна.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.



Тус байгууллагад нэмэлт санхүүжилтийн дансаар гүйлгээ хийгээгүй байна.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Үдийн хоол нийлүүлэгчийн сонгон шалгаруулалтыг харьцуулалтын аргаар зохион байгуулж, 69,768.0 мянган төгрөгийн хүүхдийн хоолны хүнсний материал худалдан авах гэрээг ЛЭМЭ ХХК, Үүрд оргих ХХК-иудтай байгуулсан байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана" гэж заасны дагуу Галуут сумын Цэцэрлэгийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг СМД аудит ХХК-ийн ахлах аудитор А.Цээням, Б.Уранчимэг нар гүйцэтгэж, анхан шатны хяналтыг компанийн менежер Б.Мөнхцацрал, хоёр дахь шатны хяналтыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Б.Нарангэрэл, аудитын менежер М.Алтантуяа, дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Галуут сумын Цэцэрлэгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл, аудитад шаардлагатай баримт материалыг СМД аудит ХХК-д 2026 оны 1 дүгээр сарын 22-ны өдөр ирүүлсэн байна.

Тайлант онд хөрөнгө захиран зарцуулах 1 дүгээр гарын үсгийг сургуулийн захирал Б.Сайнзаяа, 2 дугаар гарын үсгийг нягтлан бодогч Ц.Ундрах нар зуржээ.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2025 оны батлагдсан төсвийн зардлыг сонгож материаллаг байдлын түвшинг 1.5 хувиар тооцож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг Дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2025 оны батлагдсан төсөв /анхны төсөв/ 819,148.1 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 12,237.2 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 8,916.0 мянган төгрөгөөр тогтоосон.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Тухайн байгууллага нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хязгаарлалттай холбоотой заалтуудыг зөрчөөгүй болно.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Байгууллагын шилэн дансны нэгдсэн цахим хуудаст таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 729,265.8 мянган төгрөгийн 29 гүйлгээ, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгнөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 73,597.1 мянган төгрөгийн 11 гүйлгээг хуулийн хугацаанд мэдээлсэн байна. Шилэн дансны цахим сайтад байршуулбал зохих мэдээ, мэдээллээс сар бүр мэдээлэх байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлтийн 1 мэдээ, аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлангийн мэдээллийг хугацаа хоцроож, бусад мэдээ, мэдээллийг хугацаанд нь бүрэн байршуулжээ.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.4.2 Худалдан авах ажиллагааны талаар

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөрийн хүрээнд 63,804.5 мянган төгрөгийн хүнсний материалыг харьцуулалтын аргаар худалдан авахаар төлөвлөж, гүйцэтгэлээр 51,630.7 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Тус цэцэрлэг нь хүнсний материал материал нийлүүлэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийг харьцуулалтын аргаар зохион байгуулахаар 2025 оны 03 дугаар сарын 19-нд худалдан авах ажиллагааны цахим систем www.tender.gov.mn-д тендерийн бичиг баримтыг байршуулсан байна.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Тус байгууллагын 2025 оны 3-р улирлын байдлаархи санхүүгийн тайланд "СМД аудит" ХХК завсрын аудит алдаа, зөрчил илрээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор А.Амарзаяа гүйцэтгэж, төсвийн захирагчид балансын урамшуулал олгосон зөрчилд зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлсний хэрэгжилтийн тайланг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 05 дугаар сарын 19-ний өдрийн 35 тоот албан бичигээр ирүүлсэн байна.

Хүснэгт 4. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт /мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	1	1,544.0	1	1,544.0	100.0
Нийт дүн	1	1,544.0	1	1,544.0	100.0

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

1. Батлагдсан төсөвт хоол, унааны хөнгөлөлт тусгагдаагүй байхад Боловсролын сайдын 2025 оны "Чиглэл хүргүүлэх тухай" 1/554 тоот албан бичгийг үндэслэн Цэцэрлэгийн эрхлэгчийн 2025 оны 05 дугаар сарын 26-ны Б/11 дугаар тушаалаар өдрийн хоолны

зардлыг 5.0 мянган төгрөгөөр тогтоон, тайлант хугацаанд 13,087.2 мянган төгрөгийг олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах"; 27 дугаар зүйлийн 27.1.7-т "орлого, зарлагыг дотоод гүйлгээнээс бусад нийт гүйлгээний дүнгээр төлөвлөж, бүртгэж, тайлагнах", гэсэн заалттай нийцэхгүй байгаа тул аймгийн Боловсролын газарт зөрчил давтан гаргахгүй байх зөвлөмжийг нэгдсэн байдлаар хүргүүлэхээр шийдвэрлэсэн.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 2,774.8 мянган төгрөгийн зөрчил¹ илэрч, зөрчлийг давтан гаргуулахгүй байх 1 зөвлөмж өгсөн.

Нийт илрүүлсэн зөрчлөөс 2,774.8 мянган төгрөгийн залруулагдаагүй зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс бага тул Өөрчлөлтгүй дүгнэлт өглөө.

5.1. Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

Төсвийн төлөвлөлттэй холбоотой асуудал

5.1.1. "Баянхонгор Эко дулаан" ХХК-д халаалтын үйлчилгээний төлбөрийн 2,774.8 мянган төгрөгийн өглөгтэй гарсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-т "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.5-т "хуваарьт болон хугацаа хэтэрсэн өр төлбөрийг жилийн төсөвтөө бүрэн тусгаж өр төлбөр барагдуулах төлөвлөгөө, хуваарь баталж хэрэгжүүлэх" гэсэн заалтуудтай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн, тасалбар болголт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Халаалтын зардлыг батлагдсан төсөвт багтаан бодит гүйцэтгэлд тавих хяналтыг сайжруулж, өглөгийг тайлант хугацаанд барагдуулах талаар арга хэмжээ авч ажиллах.

Дээрх зөвлөмжийг хэрэгжүүлэн, биелэлтийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 5 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Галуут сум Хүүхдийн цэцэрлэг	1."Баянхонгор Эко дулаан" ХХК-д халаалтын үйлчилгээний төлбөрийн 2,774.8 мянган төгрөгийн өглөгтэй гарсан байна.	1	2,774.8					1	2,774.8
	ДҮН	1	2,774.8					1	2,774.8

-----oOo-----

